



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦ᠋ᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒ᠠ оны ᠐1 сарын ᠒4 өдөр

Дугаар ᠑/᠕᠑

Алтай хот

**Эрх шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:


1.Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн 70,000,000 (далан сая) төгрөгийн хөрөнгө оруулалтаар Жаргалан сумд “Цэцэрлэгт хүрээлэн байгуулах” ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гүйцэтгүүлэхийг эрхийг Жаргалан сумын Засаг дарга (П.Авирмэд)-д шилжүүлсүгэй.

2.Төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, зураг төсөл болон бусад шаардлагатай мэдээллийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор бэлэн болгож, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр ил тод, шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж, шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гүйцэтгэлээр санхүүжүүлэх, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Жаргалан сумын Засаг дарга (П.Авирмэд)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/20 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ